

МОНГОЛ УЛС  
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ  
ТОГТООЛ

1996 оны 02 дугаар  
сарын 01 –ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Маягт, заавар батлах тухай

Үнэт цаасны тухай хуулийн 22 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

1. Дотоод мэдээлэл эзэмшигч болон түүнд хамааралтай этгээдийн дансны бүртгэл хөглөх тухай маягт зааврыг 1 дүгээр хавсралтад дурдсанаар баталсугай.

2. Бүртгэлийг 1996 оны 02 дугаар сарын 15-ны дотор хөтөлж дуусгах, бүртгэлийг хадгалах, нууцыг хамгаалах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хорооны ажлын алба, Биржийн удирдлага, хувьцаат компанийн удирдлагуудад үүрэг болгосугай.

Дарга

Ж.ЯДАМСҮРЭН

Монгол Улсын Үнэт цаасны хорооны 1996 оны 02 дүгээр сарын 01-ны өдрийн 11 дугаар тогтоолын хавсралт

## ДАНСНЫ БҮРТГЭЛИЙН МАЯГТЫГ ХӨТЛӨХ, ХАДГАЛАХ ЗААВАР

1. Бүртгэлийг № А9-1 маягтаар гаргана. Бүртгэл нь: дугаар, таны болон танд хамааралтай этгээдийн овог нэр, оноосон нэр, танд ямар хамааралтай болох, брокерын пүүсийн дансны дугаар, паспортын дугаар, регистр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, тэмдэглэл гэсэн хэсэгтэй байна.

2. Үнэт цаасны хорооны дарга, гишүүн, ажилтнууд, Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн дарга, гишүүн, захирал, ажилтнууд, Үнэт цаасны компанийн удирдах ажилтан бүртгэлийг өөрөө гаргана.

3. Бүртгэл нь нууцын зэрэглэлтэй байна.

4. Хорооны гишүүд, албаны мэргэжилтний бүртгэлийг Үнэт цаасны хороонд, Биржийн болон үнэт цаасны компанийн удирдах ажилтны бүртгэлийг МХБ-д ирүүлж тус тусдаа хадгалж хамгаална.

5. Хувьцаат компанийн удирдлага, багц хувьцаа эзэмшигчид бүртгэлийг уг байгууллагын удирдлагад ирүүлж хадгалж хамгаална.

6. Маягтын асуулгад дараах байдлаар хариулж бичнэ.

1/ Маягтын “Таны болон танд хамааралтай этгээдийн овог нэр, оноосон нэр” гэсэн асуулгад:

а/ Эхлээд таны болон эхнэр, нөхрийн төрөл төрөгсдөөс /аав, ээж, ах, эгч, дүү, хүүхэд,/ брокерын пүүст данс нээлгэсэн хүмүүсийн нэрс,

б/ Дараа нь таны төрөл төрөгсдөөс брокерын пүүст данс нээлгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын удирдах албан тушаалд болон аль нэг хувьцаат компанийн нийт хувьцааны 10 болон түүнээс дээш хувийг эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажилладаг бол уг байгууллагын оноосон нэр,

в/ Эцэст нь таны төрөл төрөгсдөөс үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдэд ажилладаг бол оролцогч этгээдийн оноосон нэр,

2/ Маягтын “Таны юу болох” гэсэн асуулгад хамаарлуудыг бичнэ. Жишээ нь: “Миний эцэг, дүү, тийм компанийн захирал, ТУЗ-ийн гишүүн, тийм компанийн тэдэн хувийг эзэмшигч” гэж хариулна.

3/ “Брокерын пүүсийн дансны дугаар” хэсэгт тухайн этгээдийн дансны дугаар бичнэ.

4/ Хамааралтай этгээд хувь хүн бол “паспортын дугаар, регистр” гэсэн хэсгийг, аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан бол тухайн байгууллагын “улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар” гэсэн хэсгийг хариулна.

5/ Маягтын асуулгын “Тэмдэглэл” гэсэн хэсэгт уг этгээдийн эзэмшиж байгаа үнэт цаас /код-гоо ширхэг/, мөнгөн хөрөнгө, тухайн үнэт цаасны эзлэх хувь, хэрэв 5 хувиас дээш бол давсан үеийн огноо, дансанд хийгдсэн хөдөлгөөн зэргийг бичнэ.

7. Бүртгэл гаргагч болон бүртгэл хүлээн авагч албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

8. Эзэмшиж байгаа үнэт цааст хөдөлгөөн орсон тохиолдол бүрт үнэт цаас эзэмшигчид бүртгэлийг шинэчлэн холбогдох газарт ирүүлэх үүрэг хүлээнэ.

9. Дотоод мэдээлэл эзэмшигч болон түүнд хамааралтай этгээдийн дансны бүртгэлийг хүлээн авагч байгууллага, албан тушаалтан уг бүртгэлийг байгууллага, хувь хүний нууцын зэрэглэлээр хадгалж, хамгаалах үүрэг хүлээнэ.

10. Бүртгэл хөтлөх, хадгалах, хамгаалахад Үнэт цаасны хороо Монгол улсын хууль, эрхийн бусад актын дагуу хяналт тавина.

Нууц

Монгол Улсын Үнэт цаасны хорооны  
1996 оны 02 дүгээр сарын 01-ны  
өдрийн 11 дугаар тогтоолын хавсралт

Маягт № А9-1

**Дотоод мэдээлэл эзэмшигч болон түүнд хамааралтай  
этгээдийн дансны бүртгэл**

Дотоод мэдээлэл эзэмшигчийн овог нэр .....  
албан тушаал.....  
кодны дугаар .....

№	Таны болон танд хамааралтай этгээдийн овог нэр, оноосон нэр	Таны юу болох	Брокерын пүүсийн дансны дугаар	Паспортын дугаар, регистр	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Тэмдэглэл

1. Үнэт цаасны тухай Монгол улсын хуулийн 21, 22 дугаар зүйлийг зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ.
2. Дансны дугаарт өөрчлөлт орсон, нэмэгдсэн тохиолдолд та маягтыг дахин бичнэ.
3. Энэхүү бүртгэлийг хүлээн авсан алба, ажилтан нууцыг хамгаалах үүргийг хуулийн өмнө хүлээнэ.

Асуултад үнэн зөв хариулсан ҮЦХ, МХБ, Үнэт цаасны компани, хувьцаат  
/доогуур зур/  
компанийн ..... /албан тушаалтан/

ГАРЫН ҮСЭГ ..... /

Хүлээн авсан хүний

ГАРЫН ҮСЭГ..... /  
Албан тушаалтан.....

199.. оны ... сарын ... -ний өдөр